



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/95

Шивээговь сум

Зохион байгуулалттай арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.в, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалттай авто зам, замын байгууламж барих, ашиглах журам", аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/167 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нутаг дэвсгэрт уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тээвэрлэлтийг зогсоох, орон нутгийн чанартай авто замд төлбөр хураамж авах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ж.Батмөнх

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

О.Долгор

(Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Гишүүд:

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

А.Энхмаа


(2 дугаар багийн Засаг даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч)

Ц.Баасанжав

(Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн
хошууч)

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга хэмжээг шуурхай зохион байгуулан тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

421200270